

# СОЁМБО МЭДЭЭ

## ОРЧИН ЦАГИЙН ЗЭВСЭГТ ХҮЧИН ҮҮСЭН БАЙГУУЛАГДСАНЫ 100 ЖИЛИЙН ОЙ, "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙН БАЯРЫН МЭНД ХҮРГЭЭ!



ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
-0°C	-6°C
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
38°C	26°C
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
17°C	6°C

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,375.0	3,440.0
CNY	436.30	440.10
RUB	38.38	40.17
JPY	25.83	26.46
KRW	2.45	2.57

КОВИД-19 МЭДЭЭ	
ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	127
НИЙТ БҮРТГЭГДСЭН	4210
ЭДГЭРСЭН	3083
НАС БАРСАН	8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ	
ШИНЭЭР НЭМЭГДСЭН	12
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	242
ЭДГЭРСЭН	936

### ӨРНИЙН ЗУРХАЙ

**2021.03.17 /ЛХАГВА ГАРАГ/**

**ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ДӨРВӨН НОГООН ХӨХ ХУЛГАНА ӨДӨР**

**Үс засуулвал:**  
**Бие эрхтний хүч сайжирна**  
**Наран ургах, шингэх:**  
**07.01-19.00**

**Барилдлага: Үхэц Шүтэн** барилдлага:  
**Хүрэлцэхүй Суудал: Ус**

Аргын тооллын 3 сарын 17, Буд гараг. Билгийн тооллын 4, Гоё хүүхэн одтой, хөх хулгана өдөр. Өдрийн наран 7 цаг 01 минутад мандан, 19 цаг 00 минутад жаргана. Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, лусыг тахиж, хүүхэд үрчлэн авах, хур оруулах, дархны үйлд сайн. Улааны үйл, төлгө тавих, морь уралдуулах, сэтгэлд сэвтэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал бие эрхтний хүч сайжирна.

### МЭНДЧИЛГЭЭ



Улс Монголынхоо гал голомт, туурга тусгаар байдлыг бат найдвартайгаар батлан хамгаалж, түүхэн сорилт, шалгуур бүрийг ялгуусан туг, ялалтын уухайгаараа мөнхөлж, баатарлаг тэмцэл, бадрангүй үйлсээрээ дархалсан Монгол Улсын Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын дайчин цогтой халуун мэндийг Монголынхоо нийт ард түмэн, иргэд залуучууд, Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчинтэй ажил, амьдралаа холбосон үе үеийн эх орончид, алба хаагчид, зорилго нэгт хамтран зүтгэгчид Та бүхэндээ өргөн дэвшүүлье.

Монгол цэргийн түүх дэндүү аугаа хийгээд баялаг. "Монголын түүх бол монгол цэргийн түүх юм" гэсэн үзэл санааг олон эрдэмтэн судлаачид дуу нэгтэй хүлээн зөвшөөрдөг. Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсан түүх, түүний хөгжил, төлөвшил ч өнөөгийн Монгол орны эрх чөлөө,

тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хөгжил, цэцэглэлтэй салшгүй холбоотой, харилцан шүтэлцээтэй явж ирснийг бид мэднэ.

Монгол эх орны маань эрх чөлөө, тусгаар тогтнол нь монгол нутгийнхаа алтан хөрсөнд шингэсэн үе үеийн баатарлаг эрс, халуун эх орончдын хальсан амь, урссан цус, асгарсан хөлсний дусал бүрээр хэмжигдэх үнэ цэнтэйг түүхэн ой тохиож буй энэ цаг мөчид залуу хойч үедээ ойлгуулж, нандинган эрхэмлэж явах учиртайг ухааруулахад энэхүү түүхт ой, тэмдэглэлт арга хэмжээний зорилго, утга учир оршиж байгаа юм.

Эдүгээ 74 дэх жилдээ албан ёсоор тэмдэглэж байгаа Зэвсэгт хүчний ойн баяр бол Монголын ард түмний хувьд томоохон тэмдэглэлт баяруудын нэг, цэрэг эрсээ хүндэтгэж, тэднийхээ байгуулсан гавьяа, үйл хэргээр бахархаж ирсэн уламжлалын гүн бат илэрхийлэл юм.

Өвөг дээдсийнхээ баатарлаг, дайчин замналын залгамж халаа болсон өнөөгийн Монгол Улсын Зэвсэгт хүчин эх орноо батлан хамгаалах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлэхийн зэрэгцээ даян дэлхийн энхийн үйлс болон эх орныхоо бүтээн манлайлан оролцож, Монгол цэргийн буурал түүхийг алдар гавьяаны алтан хуудсаар улам бүр баяжуулсаар байгаад сайдын хувьд туйлын сэтгэл хангалуун байна.

Миний Батлан хамгаалахын сайдын өндөр, хариуцлагатай албанд томилогдон ажиллах хугацаандаа салбарынхаа хөгжлийг улам урагшлуулах чин хүсэл, эрмэлзлэлээ бодит ажил хэрэг болгохын төлөө төрийн хууль, бүрэн эрхийнхээ хүрээнд хичээнгүйлэн ажиллаж, шаардлагатай бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлж байгаагаар уламжлахад таатай байна. Батлан хамгаалах салбарын эрх зүйн орчныг өнөөгийн шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, хуулийн хэрэгжилтийг хангах, улс орны бүтээн байгуулалтад зохион байгуулалттайгаар оролцон хувь нэмрээ оруулах, Зэвсэгт хүчний хөгжлийн санг арвижуулах шинэ эх үүсвэрийг бий болгох, тодорхой хөрөнгийг төвлөрүүлэх замаар Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад буй зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадавх, цэргийн сургалт, бэлтгэлийн түвшнийг бодитойгоор дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг сайжруулж, ажиллаж, амьдрах ая тухтай орчныг бүрдүүлэх, цар тахлын халдвараас бие бүрэлдэхүүнийг урьдчилан сэргийлэх, эх орноо хамгаалагч дайчдынхаа амь нас, эрүүл мэндийг сахин хамгаалах зэрэг олон үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Батлан хамгаалах яамнаас дэвшүүлж байгаа бодлого, зорилтын хүрээнд амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна.

Амжилт, бүтээл бүрийн ард үүрэг, зорилгоо ухамсарласан эгэл жирийн байлдагчаас эхлээд шат, шатны захирагч, дарга нар, батлан хамгаалах салбарын нийт бие бүрэлдэхүүний сэтгэл, хүч хөдөлмөр, хичээл зүтгэл шингэсэн байдаг нь бахархалтай. Ухамсарт үйл хэргээ салбарынхаа хөгжил, дэвшлийн төлөө зориулан буй

эрхэм Та бүхэндээ чин сэтгэлийн талархал дэвшүүлж, өрнүүн их амжилтыг хүсэн ерөөе!

Эргэх орчлонгийн юмс үзэгдэл бүхэн өөрийн гэсэн цаг хугацаатай. Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн түүхэн ой тохиож буй цаг дор бид хамтдаа эх орноо батлан хамгаалах үйлст зорилго, сэтгэл нэгдэн алба хааж байна. Бидний алба хааж буй энэ цаг хугацаа, түүхэн торгон мөч дахиж хэзээ ч давтагдашгүй билээ. Тиймээс хүн бүр өөрийн хариуцсан ажил, албан тушаалдаа эзэн нь байж, хийсэн бүтээлтэй, хэлэх үгтэй, ирээдүй хойч үеийнхээ өмнө тамгалсан алтан мөртэй, гэгээн үйлстэй байх нь Та бидний эрхмээс эрхэм чухал үүрэг юм.

Ахмад үеийнхнийхээ бий болгосон хөгжлийн суурин дээр Зэвсэгт хүчнээ шинэ цагийн хөгжил дэвшилтэй нийцүүлэн хөгжүүлэх 2 дахь зуун руу хамтдаа хөл тавин алхан орж байна. Хөгжил, шинэчлэлийг гүнзгийрүүлэх асуудалд салбарын бодлого, төлөвлөлт нэн чухал нь мэдээж. Үүнээс дутахгүй хүчтэй нэг гол асуудал бол бие хүний хөгжлийн буюу хүний хүчин зүйлтэй холбоотой асуудлууд юм. Эх орноо батлан хамгаална гэдэг ойлголт өнөө цагт олон шинэлэг ойлголт, ухагдахуун, үзэл хандлагын дунд оршиж байгааг Та бүхэн анзаарч байгаа биз ээ. Тиймээс бид мэдээллийн энэ эрин зуунтай хөл нийлэн алхаж өөрийгөө бүрэн танин мэдэх, өөрийгөө тал бүрээр хөгжүүлэх, өөрийнхөө нэрийг хичээж, үргэлж сайнаар гаргахыг эрмэлзэхээс Зэвсэгт хүчний шинэ зууны хөгжил эхлэх юм. Эх орноо батлан хамгаалах үйл хэрэг салбарынхаа нэр хүндийг хамгаалахаас, өөрийнхөө нэр төрийг цэвэр, ариун байлгахаас эхэлнэ гэж товчхондоо ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл Зэвсэгт хүчин маань нэр хүндтэй, хүчтэй, хөгжил дэвшилтэй байж гэмээ нь сая улс орноо найдвартай батлан хамгаалах үндэс, суурь улам бүр баттай тавигдаж бид хамтын хүчээр Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнээ эрчимтэй хөгжүүлж чадна.

Эх орноо батлан хамгаалагч дайчин Танд Монгол цэргийн өдөр, орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, цаашдын ажил, албанд тань арвин их амжилт, амьдралд тань эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

**ДОГШИН ИХ ХАР СУЛДНИЙ ЗАЯА ХИЙМОРЬ, АРИУН ТУНГАЛАГ ХӨХ ТЭНГЭР МААНЬ МОНГОЛ ЦЭРГЭЭ МӨНХӨД СОЁРХОХ БОЛТУГАЙ!**

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР**



ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

## МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм генерал, офицер, ахлагч, цэргийн гэрээт болон хугацаат албаны түүрүүч, байлдагч, ажилтан албан хаагч, хилийн чанадад үүргээ нэр төртэй гүйцэтгэж буй энхийг сахиулагч, эх орноо батлан хамгаалах үйлсэд хөдөлмөр зүтгэл, залуу насаа зориулсан бэлтгэл болон чөлөөнд байгаа ахмад дайчид Та бүхэндээ "Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний яруу алдарт 100 жилийн ойн баярын мэндчилгээг дэвшүүлье!

Өнө эртний бахархам уламжлал, баатарлаг түүхтэй Монгол эх орныхоо бүрэн бүтэн байдал, тусгаар тогтнолын баталгаа нь болж, эрх чөлөөт ард түмнийхээ амар амгалан байдлыг өнө мөнхөд батлан хамгаалж, улс орныхоо бүтээн байгуулалт, хөгжил дэвшлийн үйлсэд үнэлж баршгүй хувь нэмрээ оруулан, монгол цэргийнхээ түүхэн амжилтыг улам бүр баяжуулсаар ирсэн үе үеийн эх орончид, ахмад дайчид, тэдний залгамж халаа болсон өнөөгийн нийт алба хаагчдынхаа алдар гавьяа, амжилт ололтоор цаг ямагт бахархаж явдгаа баярын энэ өдөр онцлоход нэн таатай байна.

Монгол нутагт үүссэн анхны төрт улсаас хойших манай орны яндашгүй баялаг түүх, баатарлаг ялалт, бахдам амжилт бүхэн нь монгол цэргийн

эрэлхэг гавьяа, идэвх зүтгэлтэй салшгүй холбоотой байдаг. Тиймээс үе үеийн монгол цэргүүд, өнөөгийн Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүн нь төрт улсынхаа эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах, ард түмнийхээ аж амьдрал, соёлыг дээшлүүлэх, бүтээн байгуулалт, гадаад харилцаа, хамтын ажиллагаа, боловсрол, шинжлэх ухаан, урлаг, спорт, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, хилийн чанадад энхийг сахиулах зэрэг бүтээлч үйл ажиллагаагаараа улс орныхоо хөгжил дэвшилтэй бүхий л сэжмээр холбогдож, ямагт манлайлагч хүчин нь байсаар ирсэн түүхтэй.

Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн хөгжлийн түүх нь улс орныхоо тусгаар тогтнол, халдашгүй дархан байдлыг хамгаалсан мятаршгүй тэмцэл, эх орондоо өргөсөн тангарагтаа чин үнэнч зүтгэсэн үе үеийн эх орончдын гавьяат үйлс, цэрэг, армидаа бүхий л талаар тусалж, хайрлаж ирсэн ард түмний сэтгэл, зүтгэл, даян дэлхийд энх амгаланг тогтоохын төлөө халуун цэгт үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагчдын түүх юм. Тиймээс бид энэхүү түүхт 100 жилийнхээ ойг монгол хүмүүн бүрийн баяр болгон өргөн дэлгэр тэмдэглэхийн хамт эрт, одоо, ирээдүйг бэлгэдсэн гурван

цагийн эргэлтэд амжилт ололт, алдаа оноогоо үнэлэн дүгнэж, цаашдын хөгжлийн чиг хандлагаа тодорхойлоло.

Өдгөө Монгол Улсын Зэвсэгт хүчин нь хөгжил дэвшлийн дараагийн зуун жилийн гараан дээр ирснээр мэргэжлийн цэрэг бүхий Зэвсэгт хүчнийг бүрдүүлж, цэргийн сургалт бэлтгэл нь шинжлэх ухаан, технологи, инновацад суурилж, бэлэн байдал, зэвсэглэл, цэргийн техник, үүрэг гүйцэтгэх чадвараар дэлхийн жишигт хүрэхийг бид зорих болно.

Энэхүү зорилго, зорилтуудыг бүтээлч ажил болгон хэрэгжүүлэхэд Зэвсэгт хүчинд мөр зэрэгцэн алба хааж байгаа бүх шатны албан тушаалтны идэвх санаачилга, хичээл зүтгэл, дэмжлэг, оролцоо чухал үүрэгтэйн дээр Та бид өмнөх амжилт ололтдоо тулгуурлан дайчин замнал, түүхэн уламжлалаараа Зэвсэгт хүчнийхээ хөгжил, төлөвшилд бодит хувь нэмрээ оруулан их үйлсийг бүтээн гэдэгт итгэл төгс байна.

Та бүхэндээ Зэвсэгт хүчний 100 жилийн ойн баярын мэндийг дахин дэвшүүлж, ажлын арвин их амжилт, амьдралд тань аз жаргал, эрүүл энх, сайн сайхан бүхнийг бэлгэдэн өрөөе!

Монгол цэргийн сүр хүч, сүлд хийморь үеийн үед мандан бадрах болтугай.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ

### ҮЙЛ ЯВДАЛ

## ХУРАНДАА ГЕНЕРАЛ ВЭЙ ФЕНХЭТЭЙ УТСААР ЯРИЛЦЛАА



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Вэй Фөнхэтэй өчигдөр утсаар ярьж, бүс нутгийн аюулгүй байдал, Батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаа, хоёр орны дотоод нөхцөл байдлын асуудлаар санал солилцов. Батлан хамгаалахын сайд нар манай хоёр орон коронавируст цар тахал дэгдэж

эхэлснээс хойш харилцан бие биедээ сэтгэлийн дэм болоод эд материалын тусламж үзүүлж, хамтдаа тэмцэж, бодит үр дүнд хүрч буйг онцолж, цаашид Батлан хамгаалахын салбарын хамтын ажиллагааг тасралтгүй өргөжин хөгжүүлж, шинэ түвшинд хүргэхийн төлөө нягт хамтран ажиллахаа илэрхийллээ.

Мөн Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр хоёр орны Батлан хамгаалах салбарын стратегийн харилцан

итгэлцлийг нэмэгдүүлэх, бүс нутгийн энх тайван, тогтвортой байдлыг хамгаалахад чухал хувь нэмэр оруулж ажиллахаа илэрхийлэв. Хариуд нь БНХАУ-ын Батлан хамгаалахын сайд, хурандаа генерал Вэй Фөнхэ Монгол, Хятад хоёр улсын иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа өндөр түвшинд хүрч, хоёр орны ард түмэн, Зэвсэгт хүчний хоорондын харилцаа өргөжиж буйд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлсэн юм.

## ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ж.ГҮРРАГЧААД ОДОН ХҮРТЭЭНЭ



ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путиний зарлигаар сансрын нисгэгч Ж.Гүррагчааг Төрийн дээд одонгоор шагнажээ.

Тус зарлигт "ОХУ болон Монгол Улсын хоорондын иж бүрэн түншлэлийг хөгжүүлэхэд

гавьяа байгуулсных нь төлөө Монгол Улсын иргэн, "Монгол-Оросын найрамдлын нийгэмлэг"-ийн Ерөнхийлөгч Жүгдэрдэмидийн Гүррагчааг Александр Невскийн одонгоор шагнасугай" гэсэн байна.

Гэгээн Александр Невскийн одонг 1725 онд бий болгосон бөгөөд Екатерина хатан хааны зарлигаар цэргийн албан хаагчид болон иргэдийг шагнаж эхэлжээ.

Сансарт ниссэн Ази тивийн 2 дахь, дэлхийн 101 дэх хүн болсон сансрын нисгэгч Жүгдэрдэмидийн Гүррагчаа нь ОХУ-ын төрийн дээд шагнал Александр Невскийн одонгоор шагнагдсан анхны Монгол иргэн болж байгаа юм.

**Эх сурвалж:**  
**Россотрудничество**  
**агентлагийн Монгол улс дахь**  
**төлөөлөгчийн газар**

## ДУУЛГА СТУДИЙН БАЯРЫН ДУГААР БЭЛЭН БОЛЛО



БХЯ-ны "Соёмбо" редакцийн "Дуулга" студийн уран бүтээлчид Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-т зориулсан баярын

тусгай нэвтрүүлгийг үзэгч олонд толилуулахаар бэлэн болгожээ. Тус нэвтрүүлгийг үзэгч Та бүхэн МҮОНТ-ийн I, II суваг, MN-25, TV-5, C-1, NTV, TV-8, ТМ телевизийн сувгаар хүлээн авч үзээрэй.

### ЦАХИМ ШУУДАНД

#### ШИЛДЭГ ЯРУУ НАЙРАГЧИД ТОДОРЛОО

336 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-ийг тохиолдуулан эх орны сэдэвт яруу найргийн наадмыг зохион байгууллаа.

Яруу найргийн өв санг баяжуулах, цэрэг дайчид, иргэд, хүүхэд залууст эх орон, тусгаар тогтнол, түүх соёлоороо бахархах

сэтгэлийг төрүүлэх, эх оронч үзлийг төлөвшүүлэх, цэрэг-эх орны сэдэвт бүтээлүүдийг сурталчлан нийтийн хүртээл болгох зорилготой тус наадамд 39 яруу найрагчийн 43 бүтээл ирснээс ахлах дэслэгч Б.Октябрь, дэд ахлагч П.Мөнхдэлгэр, ахлах дэслэгч Б.Равжих нар эхний гурван байрын эздээр шалгарав.

**Дэслэгч Ч.БОДЬГЭРЭЛ**

## ГУРВАН ҮЕИЙН УУЛЗАЛТ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн баярыг тохиолдуулан Зэвсэгт хүчний

урьд болон өнөөгийн байдал, цэргийн албаны мөн чанар, залгамж халаа, эх оронч үзэл хүмүүжлийн талаар

иргэд, хүүхэд залуучуудад мэдээлэх зорилготойгоор Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб "NTV" телевизтэй хамтран 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдөр "Гурван үеийн уулзалт" нэвтрүүлгийг зохион байгууллаа.

Тус нэвтрүүлэгт Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн захирагчаар ажиллаж байсан бэлтгэл хурандаа Д.Дондов, Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн дивизоны захирагч, дэд хурандаа Д.Төмөрхуяг, мөн ангийн салааны захирагчийн орлогч, түүрүүч П.Дөлгөөнсүх нар оролцлоо.

"Гурван үеийн уулзалт" нэвтрүүлэг нь 2021 оны 03 дугаар сарын 18-ны өдөр "NTV" телевизээр цацагдана.



### СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор  
Хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сониний редакцалд бэлтгэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл болон сониний нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сониний мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018

И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029